




3.1 Төгсөлт, дэвшилтийн бүртгэлийн үйл ажиллагаа

Систем дээр “Хичээлийн жилийн хаалт” хийж дараагийн “Хичээлийн жилийн нээлт” хийх үйл ажиллагааг цэцэрлэгүүд өөрийн эрхээр удирдах бөгөөд төгсөлт, дэвшилтийн бүртгэлээ урьдчилан баталгаажуулсан байх шаардлагатай.



- Цэцэрлэгүүд “Төгсөлт, дэвшилтийн бүртгэл”-ийг бүх бүлэг, суралцагчийн хувьд бүрэн баталгаажуулна.
 - “Төгсөлт, дэвшилтийн бүртгэл” хийхээс өмнө дараагийн хичээлийн жилийн анги, бүлгийг шинээр үүсгэх бэлтгэл ажлыг арга зүйч урьдчилан хийсэн байна.
 - Дэвших шийдвэртэй суралцагчдын хувьд дараагийн хичээлийн жилийн аль анги, бүлэгт үргэлжлүүлэн суралцахыг сонгож өгнө.
 - Хувилбарт сургалтанд хамрагдагч суралцагчдын хувьд зөвхөн төгсөх шийдвэртэйгээр бүртгэл хийнэ.
 - Төгсөх шийдвэртэй суралцагчдын хувьд дараагийн хичээлийн жилд цэцэрлэгээс гарах учир ямар нэгэн анги, бүлэгт хуваарилахгүй.
- Цэцэрлэгүүд “Төгсөлт, дэвшилтийн бүртгэл” -ээ бүх бүлэг, суралцагчийн хувьд бүрэн баталгаажуулж дуусгаад “Хичээлийн жилийн хаалт” үйлдэл хийнэ.
- Цэцэрлэгүүд “ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ХААЛТ” үйлдлийг хийхэд дараагийн “ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НЭЭЛТ” систем дээр хийгдэж дэвших суралцагч нь дараагийн анги бүлэгтээ дэвшин орж, төгсөх суралцагчид цэцэрлэгээс автоматаар хасагдана.

Арга зүйч болон ангийн багш дараах үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

Модуль	 Бүлгийн багш	 Арга зүйч
Анги, бүлэг		<ul style="list-style-type: none">Дараагийн хичээлийн жилийн анги, бүлэг шинээр үүсгэх
Дэвшилт	<ul style="list-style-type: none">Төгсөлт, дэвшилтийн бүртгэлБаталгаажуулах хүсэлт илгээх	<ul style="list-style-type: none">Төгсөлт, дэвшилт баталгаажуулахТөгсөлт, дэвшилт цуцлах